



ДУНДГОВЬ АЙМАГ  
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/17

Мандалговь

Байгууллагын эцэг эхийн зөвлөл  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйл, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мал эмнэлгийн газрын эцэг эхийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.


Үүнд: Гишүүд П.Чинбат /шимэгчтэх, халдваргүй өвчин, малын эм, биобэлдмэлийн хэрэглээний асуудал хариуцсан мэргэжилтэн/

Н.Балданжав /нярав, бичиг хэргийн ажилтан/

Л.Цэрэннадмид /мэргэжилтэн/

2. Эцэг эхийн зөвлөл нь үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж, байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийн авъяас чадварыг хөгжүүлэх, боловсрол эзэмшүүлэх, хөмүүжилд нь эцэг эх багш нартай хамтран ажиллаж, хүүхдэд чиглэсэн бусад үйл ажиллагааг зохион байгуулж, зөвлөлийн үйл ажиллагаагаа нийт албан хаагчдад тайлагнаж ажиллахыг үүрэг болгосугай.

3. "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах" өдрийг тохиолдуулан жил бүр байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийн дунд ажил зохион байгуулахыг эцэг эхийн зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.МӨНХДҮҮРЭН



4801200063